

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 10 -ны өдөр

Дугаар

БА-062/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 37 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 2 блок, 19 (арван ес) автомашины дулаан зогсоолтой, 225 (хоёр зуун хорин таван) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/05/14 огноо, 0012507 дугаар, БАЗГ2023/122;

2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар КМ-21-03-406;

2.3 Захиалагч: Бүргэд Констракшн ХХК оноосон нэр, 9011189087 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5309557 регистрийн дугаар, БУ11-89/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, 10-р хороолол, 46 байр, 09 тоот, 89119033 холбоо барих утас, [burgedconstruction@gmail.com](mailto:burgedconstruction@gmail.com) цахим хаяг;

2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: Бүргэд Констракшн ХХК оноосон нэр, 9011189087 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5309557 регистрийн дугаар, БУ11-89/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, 10-р хороолол, 46 байр, 09 тоот, 89119033 холбоо барих утас, [burgedconstruction@gmail.com](mailto:burgedconstruction@gmail.com) цахим хаяг;

2.5 Барилга байгууламжийн Туслан гүйцэтгэгч байгууллага: "И БИ И" ХХК оноосон нэр, 9011045116 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5525659 регистрийн дугаар, БУ11-748/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо, Өнөр хороолол, 36-р сургуулийн байр, 9499-4509 холбоо барих утас, [nyamkhorloo@ebengineering.org](mailto:nyamkhorloo@ebengineering.org) цахим хаяг;

“Хос Титэм Хаус” ХХК оноосон нэр, 9011352075 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5607612 регистрийн дугаар, БУХ2-390/17 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, монелийн гудамж, 2-19 тоот, 99134667 холбоо барих утас;

“Хос Болор Талст” ХХК оноосон нэр, 9011368117 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5632226 регистрийн дугаар, 51/22-057 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Монхаус 33/1, 05 тоот, 99039034 холбоо барих утас;

“Нялгын Илч” ХХК оноосон нэр, 9011826565 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6689027 регистрийн дугаар, БУ12-845/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, 16-р хороолол, Дандарбаатарын гудамж, 28-р байр, 24 тоот, 99997111 холбоо барих утас;

“Оргилох Эрчим” ХХК оноосон нэр, 9011314065 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5530431 регистрийн дугаар, Д-2191/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо, 2-41 тоот, 88025537 холбоо барих утас;

“Цамхаг Констракшн” ХХК оноосон нэр, 9011084097 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2768275 регистрийн дугаар, ӨБ19-693/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Экспресс тауэр 403 тоот, 89116744 холбоо барих утас;

“Хайкик” ХХК оноосон нэр, 9011314030 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5525659 регистрийн дугаар, БУ19-896/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Режис плэйс 1104 тоот, 88010513 холбоо барих утас;

2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Криетив Монголиа” ХХК оноосон нэр, 9011419094 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5726824 регистрийн дугаар, ЗТ11-313/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар;  
Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө, 69-р байр, 84 тоот, 99113143 холбоо барих утас, [zb.eng9@gmail.com](mailto:zb.eng9@gmail.com) цахим хаяг;

2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: “Голд Компасс” ХХК оноосон нэр, 9011025043 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5017971 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, 19-р хороолол, Нэхмэл 3, 3 тоот, 99169782, 88045277 холбоо барих утас;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан;**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар, 2 блок, 19 (арван ес) автомашины дулаан зогсоолтой, 225 (хоёр зуун хорин таван) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

АЛТ ШАЛГАЛ  
ГАЗАР

байгууламжийг ашиг  
орлуулах комиссо

3.4 Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 8 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

### Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 2 блок, 19 (арван ес) автомашины дулаан зогсоолтой, 225 (хоёр зуун хорин таван) айлын үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

ТҮЙН

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо, Бүргэд Констракшн ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар, 2 блок, 225 (хоёр зуун хорин таван) айлын үйлчилгээтэй орон сууцны барилга

Комиссын дарга:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Бүргэд Констракшн ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



(Ч.Цогсайхан)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 37 ДУГААР ХОРОО /ӨРНӨХ ХОРООЛОЛ/  
“БҮРГЭД КОНСТРАКШН” ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 16 ДАВХАР  
2 БЛОК, 19 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ  
225 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо /Өрнөх хороолол/ “Бүргэд констракшн” ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар 2 блок, 19 автомашины дулаан зогсоолтой, 225 айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын нэгдүгээр давхарын үйлчилгээний зааланд 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 9:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга:  
Нийслэлийн хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг
2. Нарийн бичгийн дарга: Бүртгэд констракшн ХХК-ийн  
Төслийн удирдагч Д.Батбаатар
3. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын  
Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын  
хэлтсийн Барилга техникийн хяналтын  
улсын байцаагч Н.Ёндонсамбуу
4. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын  
Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн  
Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн  
хяналтын инженер Б.Оргил
6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн  
техник хяналтын инженер Ц.Наранцацрал
7. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн  
Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн Н.Даваадэмид
8. Ус сувгийн удирдах газрын Шинэ хэрэглэгчдэд  
үйлчлэх албаны менежер Б.Жамбалцанжид
9. Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын  
зураг төслийн хяналтын байцаагч, дэд хурандаа М.Батсайхан
10. Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын  
архивын архивч Б.Оюунжаргал
11. Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын  
материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батням
12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг  
хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй

иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан	Б.Ганзориг
13.Голд Компасс ХХК-ийн Ахлах инженер	М.Энхбаяр
14.Зураг төсөл зохиогч “Криетив Монголиа” ХХК-ийн инженер	Б.Содном
15.Ерөнхий гүйцэтгэгч “Бүргэд констракшн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал	Ч.Цогсайхан

#### ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан –15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан–15

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо /Өрнөх хороолол/ “Бүргэд констракшн” ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар 2 блок, 19 автомашины дулаан зогсоолтой, 225 айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилга техникийн хяналтын улсын байцаагч **Н.Ёндонсамбуу**:

- Лифтний албан шаардлага, биелэлтийн хамт үзүүлэх
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа гаргаж үзүүлэх/14,3: 14,6/
- Ерөнхий төлөвлөгөөнд тайлбар, албан тоот ирүүлэх
- Бетоны лабораторийн гэрчилгээ үзүүлэх /нэршил тодорхой давхар бүр/
- Өөрчлөлтийн зураг хийлгэж эрх бүхий байгууллагаар баталгаажуулах
- Ил далд ажлын акт үзүүлэх /лифтний хажуу өрөө/
- D айлын 1 өрөөний айл амьдрах стандарт норм дүрэм хангагдсан эсэх арга хэмжээ авах/
- Айл өрх хаалга мөргөлдөж байгаад тайлбар албан тоот ирүүлэх
- Дулаан зогсоолын тоо тодорхой болгох
- Техникийн давхарт айл амьдрахгүй байх баталгаа албан тоот ирүүлэх
- Техникийн давхрыг бүрэн дуусгах
- Дээврийн хог шүүгч солих
- Айл өрхүүдийн аваарын гарцыг налуу болгох
- Айл өрхүүдийн цонх цантаж байгаад тайлбар өгөх
- Цонх 3 давхар шиллэгээ хийгдээгүй тайлбар, дулаан техникийн тооцоо хийлгэх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**:

- Гадна дулааны 2,3-р худгаас гарч байгаа уурын шалтгааныг тодорхойлж хэвийн болгох, худагт ус буулгагч, агаар гаргагч фото зургаар баримтжуулан шалгуулах
- Холигч насосны үзэлд зургийн дагуу нам цэгт /шугаманд/ ус буулгагч хийх
- Холигч насосны 2 үзелийн өрөөнд ус зайлуулах трап хийх
- Айлуудын халаалтын коллектор цэвэрлэн, шугам будаж хаягжуулах
- Гадна, дотор ус, дулааны шугаманд хэрэглэсэн трубуны тохирлын гэрчилгээ шалгуулах
- Дээвэр дээрх ердийн системийн шахтанд байрлах дээвэр дээр шагайвчнаас дээш гарсан үнэр гаргагчийг дулаалах, таганд “Т” тройник угсрах
- Нөөцийн сав ариутгал хийлгэж, ундны усны шинжилгээ өгч НЭМГ-ын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулах,
- Гадна дулаан, цэвэр бохир усны шугам угсарсан ААН-н тусгай зөвшөөрөл, ил далд ажлын акт шалгуулах
- Техникийн давхрыг айл өрхөөр ашиглахгүй байх баталгаа гаргах
- Гадна шугам мэдээллийн санд оруулах

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Хяналтын инженер **Б.Оргил:**

- Дулааны үзель хаягжуулах, айлуудын коллектор цэвэрлэгээ үйлчилгээ хийх
- Халаалтын дотор системд тохируулга зүгшрүүлэлтийн ажил хийх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер **Ц.Наранцацрал:**

- 0.4кв-ын кабелийн ил далд ажлын акт болон нийслэлийн мэдээллийн санд бүртгүүлсэн акт
- Аянгийн хүрээний ил далд ажлын актыг нөхөн бүрдүүлэх
- Лифтний өрөөний тоноглолын суурь болон дээврийн салхивчны малгайг газардуулгын хүрээтэй холбож гагнах
- Цахилгааны ерөнхий щитийг хөдөлгөөнгүй бэхлэх, кабель шугамд хаягжуулалт хийх, схем байршуулах
- Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, лифт болон дулааны үзелийн хэрэглээнд тус тусад нь тоолуур тавих
- Техникийн нөхцлийн 3-р заалт, орон сууцны болон нийтийн эзэмшлийн хэрэглээ, айл өрх, үйлчилгээний хэсэгт ухаалаг тоолуур тавих
- Барилга баригдах үеийн болон газраа чөлөөлсөн айл өрхийн цахилгааны төлбөр тооцоог барагдуулж тооцоо нийлсэн акт авах
- Хүчит иөхөөрөмжийг батлагдсан зургийн дагуу хийгдсэнд гүйцэтгэлийг зургаар баталгаажуулах

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн Сүлжээ төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид:**

- Галын системийн утаа мэдрэгч бүрэн шалгаж залгааг сайжруулан ажилд оруулж аюулгүй байдлыг хангах

- Давхрын самбар дахь кабель шугамыг цэгцлэх, бэхэлгээг сайжруулан, залгааг стандартын дагуу хийж гүйцэтгэх
- Домофон системийн дүрс харилцуурыг дуут харилцуур болгон өөрчилсөн тайлбар өгөх /бичгээр/
- Камержуулалтыг зургийн дагуу давхар болгонд хийж гүйцэтгэх
- Холбооны өрөөний өөрчлөлтийн талаар тайлбар бичиг өгөх
- Холбооны тавиур хаягжуулах

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер **Б.Жамбалцанжид:**

- Цэвэр усны худагт галын гидрант суурилуулах
- Гадна цэвэр усны гүйцэтгэлийн зурагт ДХЗ-г оруулах
- ДХ1-т цэвэр усны шугамын хаалтыг фланцтай хаалтаар солих

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, дэд хурандаа **М.Батсайхан:**

- Зоорь, 1-р давхар, техникийн давхарт өөрчлөлт орсон. Зураг төсөл хянуулах
- ОБЕГ-ын ГТУХАБ-ын 2021оны 07-р сарын 09-ний өдөр хянаж баталгаажуулсан зураг төслөөс барилгын дулаалга материал өөрчилсөн. Тайлбар албан бичиг өгөх /гадна хананд/
- Техникийн давхрын ил явсан агаар сэлгэлтийн системийг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх
- 1-р давхрын нийтийн эзэмшлийн дотор заслын материал нь гал тэсвэрлэлтийн зэрэг хангаж байгаа эсэх дүгнэлт үзүүлэх, зохиогч тайлбар өгөх
- Батлагдсан зураг төслийн дагуу авто зогсоолыг 16 авто машинаар тэмдэг тэмдэглэгээг хийж дугаарлах
- Цахилгааны ерөнхий щитний өрөөнд бие даасан гал унтраах автомат төхөөрөмж хийх
- Гал унтраах автомат спинклерийн системийн төгсгөлд даралт хэмжигч /манометр/ суурилуулах
- Цэвэр усны худагт галын гидрант хийх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын Архивч **Б.Оюунжаргал:**

- Архивд баримтаа “Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм”-ийн 5-р хавсралт, жишиг жагсаалтын дагуу бүрэн бүрдүүлж өгөх
- Хувийн хэрэг, ил далд ажлын акт, барилгад хэрэглэсэн материалын гарал үүсэл баримтад дотоод товъёг стандартын дагуу хийх
- Барилга угсралтын тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулах, гарчиглах /ажлын үе шатаар/
- Барилгын хувийн хэргийг н/жагсаалтын дагуу зөв бүрдүүлж өгөх

- Ажлын болон өөрчлөлтийн зургийг эх хувир өгөх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга **С.Батням:**

- Материалын тохирлын гэрчилгээ байхгүй
- Цонх- Эрчим хүчний хэмжилтийн төвөөс шинжилгээний бичиг авах
- Гадна дулаалгын хөөс – Онцгой байдлаас галын шинжилгээний бичиг авах
- Дээвэр ямар материал ажилласан тодорхойгүй
- Арматур тохирлын гэрчилгээ байхгүй /Барилгын тухай хууль 43.1.3/
- Техникийн давхрын үндсэн бүтээцэд өөрчлөлт оруулсан, зориулалт өөрчилсөн
- Нөөцийн усны сав
- Гадна фасад өөрчлөгдсөн
- Нормчлолын санг төвлөрүүлэн тооцоо хийх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан

**Б.Ганзориг:**

- Нийтийн ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж тохижуулах
- Лифтний зарлан мэдээллийг ажиллуулах
- В1 давхрын авто зогсоолыг тэргэнцэртэй хүн ашиглах боломжгүй байгаа тул оновчтой шийдлийг олж шийдэх
- Хүүхдийн тоглоомын хэсэг рүү явж буй замын доголыг, авто зам руу орж байгаа болон гаражийн хажуугийн огцом доголуудыг засах, дараагийн барилгад анхаарах

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Ашиглалт хариуцах Голд Компасс ХХК-ийн Ерөнхий инженер **М.Энхбаяр:**

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Зураг төсөл зохиогч Криетив Монголиа ХХК-ийн инженер **Б.Содном:**

- Зураг төсөлд гарсан өөрчлөлтүүдэд зураг төсөл зохиогчтой зөвшилцөж өөрчлөлтийн зураг гаргаж батлуулах

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

“Бүргэд констракшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал **Ч.Цогсайхан:**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна

“Бүргэд констракшн” ХХК-ийн Төслийн удирдагч: **Д.Батбаатар:**

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг:**

- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгааг албан бичгээр ирүүлэх
- БНБД 11-04-16 Зохиогчийн дүгнэлт шинэчлэн ирүүлэх /бүх өөрчлөлт хийсэн ажлыг тусгах/
- Зоорийн давхрын дулаан зогсоолын өөрчлөлтийн зургийг онцгой байдалтай зөвшилцөх
- Техникийн давхрын өрөөнүүдийг зөвшөөрөгдсөн зориулалтаар ашиглах баталгааг албан бичгээр ирүүлэх

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Баянзүрх дүүргийн 37 дугаар хороо /Өрнөх хороолол/ “Бүргэд констракшн” ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар 2 блок, 19 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 225 айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч



(Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн.

Нарийн бичгийн дарга:  
Бүргэд Констракшн ХХК-ийн  
Төслийн удирдагч



(Д.Батбаатар)